



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 4/303

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 6 дугаар хуралдааны 6 дугаар тогтоолын 3 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт тусгагдсан "Ахмадын ордон байгуулах" ажлын хүрээнд Орон нутгийн өмчийн газраас зарласан ХЭАОНӨГ/201801008 дугаартай Объект худалдан авах тендерт шалгарч гэрээт хугацаанд нийлүүлэх хүсэлт ирүүлсэн "Түмэн дэмбэрэл хайрхан" ХХК-ий барилга объекттой танилцан хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Чогсомжав	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Баттулга	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Г.Лхагвахатан	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Д.Зоригтбаярмаа	-Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл, ашиглалт, хяналтын мэргэжилтэн
	Ч.Адьяа	-Аймгийн Ахмадын хорооны дарга

2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч буй объектын чанар байдлыг техникийн тодорхойлолттой харьцуулан танилцаж хүлээн авах, Орон нутгийн өмчид бүртгэх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА